



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠔ оны ᠐᠑ сарын ᠒8 өдөр

Дугаар ᠓/᠒᠑᠑

Алтай хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл арга хэмжээний хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ГААОНӨГ/202312010 дугаар бүхий инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах, сэргээн засварлах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүд: С.Баярмаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хүнс, хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн)
- Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
- Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга угсралт техник хяналт хариуцсан мэргэжилтэн) (Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга)
- Нарийн бичгийн дарга: Э.Пүрэвдорж (Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Худгийг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, ашиглалт хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР